



ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 06 өдөр

Дугаар А/04

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, мөн зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, мөн хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, мөн хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус газрын 2020 онд өөрийн хөрөнгөөр санхүүжих Улсын мэдээллийн маягт худалдан авах ажлыг зохион байгуулах, гүйцэтгэгчийг нээлттэй шалгаруулалтын журмаар сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Эрх зүй, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн С.Цоггэрэл
Нарийн бичгийн дарга: Мэргэжилтэн Г.Ууганцэцэг

Гишүүд: Хууль зүй, дотоод хэргийн яамны, Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн О.Даваажаргал
Бүртгэлийн мэргэжилтэн Д.Энхчимэг
Худалдан авах ажиллагааны хөтөч багш Н.Батболд

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ


С. ГАНЗОРИГ

000015